| 111 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүү | - | 11,880,300.00 | (11,880,300.00) | 0.0 |
| 112 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүү | - | 17,649,474.19 | (17,649,474.19) | 0.0 |
| 114 | Гадаадын эх үүсвэрээс санхүүжих | - | 8,690,000.00 | (8,690,000.00) | 0.0 |
| 127 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний | - | 5,000,000.00 | (5,000,000.00) | 0.0 |
| 128 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсий | - | 500.00 | (500.00) | 0.0 |
| 133 | АЖИЛЛАГСДЫН ТОО | 79.00 | 79.00 | - | 100.0 |
| 134 | Удирдах ажилтан | 1.00 | 1.00 | - | 100.0 |
| 135 | Гүйцэтгэх ажилтан | 44.00 | 44.00 | - | 100.0 |
| 136 | Үйлчлэх ажилтан | 34.00 | 34.00 | - | 100.0 |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймаг Баянчандмань суман дахь политехникийн коллеж нь Мал аж ахуй, мал эмнэлэг, уул уурхай, нөхөн сэргээлтийн чиглэлээр болон шаталсан сургалттай мэргэжлийн анхан, дунд шатны сургалт эрхлэн орчин цагийн техникийн чадварлаг мэргэжилтэн бэлтгэх зорилготой Боловсрол шинжлэх ухааны яамны харьяа байгууллага юм.

Тус байгууллага нь 79 батлагдсан орон тоотой боловч 2023 онд 68 ажиллагсадтайгаар үйл ажиллагаа явуулсан байна. Үүнд: Удирдах ажилтан 1, гүйцэтгэх 46, үйлчилгээний 21 ажилтан ажиллаж байна.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Төв аймаг Баянчандмань суман дахь политехникийн коллеж үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Төв аймаг Баянчандмань суман дахь политехникийн коллеж нь төсвийн шууд захирагчийн хувьд дараах хуулийн хүрээнд  төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль,
- Төсвийн тухай хууль,
- Байгаль орчныг хамгаалах тухай хууль
- Аялал жуулчлалын тухай хууль
- Нийгмийн даатгалын тухай хууль
- Монгол улсын 2023 оны төсвийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль,

- Шилэн дансны тухай хууль,
- Төрийн хэмнэлтийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжууд, мөн Сангийн яам болон харьяа яамнаас гаргасан тушаал, заавар журам шийдвэрүүдийг мөрдөж ажиллаж байна.

Төв аймаг Баянчандмань суман дахь политехникийн коллеж 2023 оны 11 сард Төв аймгийн Засаг даргын нэрэмжит үзлэг шалгалтад хамрагдаж, 92%-тай дүгнэгдсэн. Мөн 2023 онд Төв аймгийн санхүү хяналт, аудитын албанаас 2021-2022 оны санхүүгийн тайланд хяналт шалгалт хийж шилэн дансны мэдээлэл, нягтлан бодох бүртгэл, анхан шатны бүртгэл хөтлөлт шаардлагын түвшинд гэж дүгнэсэн байна

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт *үр нөлөөтэй* байна.

Дотоод аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах /дотоод аудитораас шууд туслалцаа авах *шаардлагагүй* гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймаг Баянчандмань суман дахь политехникийн коллеж 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг *аккруэл* сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад *нийцсэн,*тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт *тохирсон* байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймаг Баянчандмань суман дахь политехникийн коллеж 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 365,862.2 мянган төгрөгөөр буюу 6,1 хувиар *буурсан* байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| **Мөнгөн хөрөнгө** | 5,000.0 | 0.5 | 4,995.0 |
| **Авлага** | 12,353,0 | 21,018.0 | 9,125.0 |
| **Урьдчилгаа** | | | |
| **Бараа материал** | 273,771.0 | 366,765.9 | 92,994.9 |
| **Үндсэн хөрөнгө** | 5,803,629.0 | 5,341,106.3 | (462.522.6) |
| **Биет бус хөрөнгө** | 603,633,3 | 605,684,3 | 2,051,0 |
| **Нийт хөрөнгө** | **6,094,753,0** | **5,728,890.8** | **(365.862.2)** |

| | | | |
|---|---|---|---|
| **Өр төлбөр** | 14,562,3 | 10,539,2 | (4.023.1) |
| **Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/** | 6,080,190.7 | 5,718,351.6 | (361.839.1) |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **6,094,753,0** | **5,728,890.8** | **(365.862.2)** |

Дээрх хүснэгтээс харахад: Мөнгө дансны үлдэгдэл 0.5 мянган төгрөг болж, 4,995.0 мянган төгрөгөөр буурсан нь мөнгөн зарлага нэмэгдсэнтэй холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 92,994.9 мянган төгрөгөөр өссөн. Энэ нь:

- Бараа материал дансны үлдэгдэл 92,994.9 мянган төгрөгөөр өссөн нь өртгийн зардал өссөнтэй холбоотойгоор хичээл үйлдвэрлэлийн дадлагын зардал гүйцэтгэлд суурилсан санхүүжилтээс хамааран багш нарын дадлага хийлгэх материал, сургалтын хэрэглэгдэхүүн болгож ерөнхий эрдмийн багш нарт хэрэглэгдэхүүн 41,335.8 мянган төгрөгөөр авсан, хоолны материалын зардлын үнэ өссөн, хөдөө аж ахуйн чадамжийн хөтөлбөр хэрэгжсэнтэй холбоотой сурах бичиг худалдан авсан зэргээс шалтгаалан нэмэгдсэн байна.
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 5,341,106.3 мянган төгрөг болж өнгөрсөн оны мөн үеэс 462,522.6 мянган төгрөгөөр буурсан нь: 2023 онд улсын төсвийн хөрөнгөөр 27,426.8 мянган төгрөгийн их засвар, тоног төхөөрөмжийг орлогод авсан. Хандиваар 77,506.5 мянган төгрөгийн тоног төхөөрөмж тавилга хэрэгслийг хүлээн авсан.

Тайлант онд Төв аймгийн орон нутгийн өмчийн газрын 2023 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 05/324 тоот албан тоотын дагуу Баянчандмань сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 04 тоот тогтоолоор үлдэх өртөггүй болсон барилга байгууламж, авто тээврийн хэрэгсэл, машин тоног төхөөрөмж, бусад үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгө зэрэг 187,147.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг данснаас хасаж, 47,986.7 мянган төгрөгийн тоног төхөөрөмж тавилга эд зүйлсийг дахин үнэлж орлогот авсан, дуудлага худалдаагаар 42,112.5 мянган төгрөгийн авто тээврийн хэрэгслийг худалдаж данснаас хассан, 48 нэр төрлийн 35,176.3 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшлыг акталж данснаас хассан зэргээс шалтгаалж үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл нийт 462,522.6 мянган төгрөгөөр буурсан байна.

Тайлант онд 131,976.9 мянган төгрөгийн элэгдлийг шулуун шугамын аргаар байгуулсан.

Өглөг дансны үлдэгдэл 10,539.2 мянган төгрөг байгаа нь УБТЦС ХХК, МЦХ зэрэг газруудад өгөх өр үүссэн байна. Тус өрийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 2,357,331.7 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 692,006.5 мянган төгрөг, нийт 3,049,338.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төслийг 3,049,338.2 мянган төгрөгөөр баталсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 2,357,331.7 мянган төгрөгийг улсын төсвөөс, 692,006.5 мянган төгрөгийг орон нутгийн

төсвөөс, 38,219.8 мянган төгрөгийг үйл ажиллагааны орлогоос нийт 3,087,558.0 мянган төгрөгийн төсөв бүрдүүлжээ.

Үндсэн үйл ажиллагааны зардлын гүйцэтгэл 3,028,326.7 мянган төгрөг буюу 99,3 хувьтай байгаа нь ажил олгогчоос олгох цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг 18,873.0 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| **80302** | Тусгай мэргэжлийн боловсрол анхан шатны нэг иргэн | 441,664.4 | 367,211,3 | 74,453 | 95,4 |
| **81603** | Үндсэн мэргэжлийн тусламж үйлчилгээ | 139,671.1 | 71,598,2 | 40,928.4 | 95,3 |
| **83603** | Дээд шатны төсвөөс хуваарилсан | 18,907.6 | 12,484,4 | 19,116.7 | 80,6 |
| **80111** | Төрийн өмчийн барилгын тогтмол зардал | 38,223,0 | 35,310.2 | 2,912.8 | 100,0 |
| **71602** | Үндсэн үйл ажиллагааны зардал | 2,410,872.1 | 2,541,722.6 | 130,850.5 | 105.4 |
| | дүн | 3,049,338.2 | 3,028,326.7 | 21,011.5 | 99,3 |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн тайлан байхгүй

### 3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

1 хөтөлбөр 2 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

*Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт*

/мянган төгрөгөөр/

| № | Хөтөлбөр | Хэрэгжих хугацаа | Хүрэх үр дүн | Хэрэгжилтийн явц | Зарцуулах төсөв | Зарцуулсан |
|---|---|---|---|---|---|---|
| **1** | 71411-80102 | 2023,12,31 | 1 иргэн нормативаар | 83,1% | 441664.4 | 367,211,3 |
| **2** | 71411-81603 | 2023,12,31 | Үндсэн мэргэжлийн тусламж үйлчилгээ | 51,3 | 139,671,1 | 71,598.0 |
| **3** | 71411-80602-80603 | 2023,12,31 | Дээд шатны төсвөөс | 66,0 | 18,907,6 | 12,484.4 |
| **4** | 71411-80111 | 2023,12,31 | Төрийн өмчийн барилга тогтмол зардал | 100,0 | 38,223,0 | 35,310,2 |

Хэрэгжилт хангалтгүй биелэгдсэн 1 арга хэмжээ байна. Энэ нь Мэргэжлийн тусламж үйлчилгээний арга хэмжээ нь цахим болон танхим хосолсон сургалтаас хүүхдийн тоо хэлбэлзэлтэй байснаас шалтгаалсан гэж үзжээ.

### 3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Цахим дэлгүүрээс худалдан авалт хийгдээгүй.

Төрийн худалдан авах ажиллагааны зохих хууль журмын дагуу 2023 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг батлуулан ажилласан байна.

Суралцагсдын хоол, хүнсний бараа материал, харуул хамгаалалтын ажил үйлчилгээ нийлүүлэлт, хичээл үйлдвэрлэлийн дадлагын бараа материал нийлүүлэлтийн тендерүүдийг тус тус журмын дагуу зарласан бөгөөд нэг ч аж ахуй нэгж оролцоогүй. Хоол хүнсний материалаа Жигүүр кэйтеринг ХХК, Тамирын хүлэг ХХК, Номин инж ХХК-с 221,763.0 мянган төгрөгийн худалдан авалт тус тус хийлээ.

Харуул хамгаалалтын ажил үйлчилгээг АМУ ЭКО КОНСТРАКШН ХХК 55,199.0 мянган төгрөг ажил үйлчилгээ хийсэн. Хичээл үйлдвэрлэлийн дадлагын материал хэрэглэгдэхүүний зардалд 154,815.3 мянган төгрөгийн худалдан авалтыг МТ ХХК, Их дөрвөлж ХХК, Од орд ХХК, Санжид буян ХХК, Эй би экспресс ХХК, Ө.Батнасан, Чой судар ХХК, Хос бэрс металл ХХК, Октава ХХК, Расэнган ХХК, Зулбаяр, Алт бил хул ХХК -аас тус тус худалдан авалт хийсэн байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймаг Баянчандмань суман дахь политехникийн коллежийн 2023 оны оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, хөрөнгийн болон зардлын бүртгэл, анхан шатны бүртгэлтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Релаэнс секюритиз аудит ХХК-ийн аудитор С.Дашдондог, аудитор Б.Мягмар нар гүйцэтгэж, хяналтыг Релаэнс секюритиз аудит ХХК-ийн захирал, аудитор Ж.Цэцэгмаа, Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер О.Амаржаргал, дарга тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймаг Баянчандмань суман дахь политехникийн коллеж 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Релаэнс секюритиз аудит ХХК-д 2024 оны 02 дугээр сарын 16-ны өдрийн 1/13 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Төв аймаг Баянчандмань суман дахь политехникийн коллеж 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож , материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг Бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2,0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Төв аймаг Баянчандмань суман дахь политехникийн коллеж 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,795,000.0 мянган төгрөгөөс 2,0 хувиар буюу 35,900.0 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 28,720.0 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох *шаардлагагүй* гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тус байгууллага 6 арга хэмжээний заалт бүхий төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж ажилласнаар цалин хөлстэй холбоотой орон тоо хэмнэсэн, нормативт зардал, хангамжийн бараа материал зэргийг төлөвлөгөөт хэмжээнд зарцуулах буюу хэмнэх арга хэмжээ авч ажилласан байна.

Гэвч тайлант онд авлагыг 8,665.0 мянган төгрөгөөр өмнөх оноос нэмэгдүүлсэн, Өглөг дансыг 4,023.1 мянган төгрөгөөр бууруулсан боловч өр төлбөрийг бүрэн барагдуулаагүй байна.

Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт хангалтгүй гэж үзлээ.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны хуулийг шалгахад 2023 онд Төв аймаг Баянчандмань суман дахь политехникийн коллеж нь 2023 онд 159 мэдээллийг шилэн дансанд байршуулахаас 157 мэдээллийг байршуулж 2 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дугаар зүйлийн 4.1.1-д “Мэдээлэл үнэн зөв бодитой иж бүрэн байх”, 4.1.3-д “тогтоосон хугацаанд тогтмол шуурхай мэдээлдэг байх”, 6.4.4-д “Таван саяас дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа ажил гүйлгээ”, МУЗГ-ын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 7 дугаар зүйлийн 7.5.3-д “өөрийн хянах цэсийн мэдээллийг байнга хянах” заалтуудыг хэрэгжүүлээгүй байна.

*<u>Шийдвэрлэсэн нь</u>*:
Шилэн дансны хууль, журмын заалтуудыг хэрэгжүүлэн ажиллахыг анхааруулав.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймаг Баянчандмань суман дахь политехникийн коллежийн 2023 оны 9 дүгээр сарын 30-наар тасалбар болсон төсвийн гүйцэтгэлийн тайланд хийгдсэн. Завсрын аудитын явцад зардлын данстай холбоотой 78,700.0 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгөгдсөн ба биелэлтийг жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дахин хянахад 1 зөвлөмж нь хэрэгжээгүй тул аудитын тайланд тусгаж зөрчлөөр оруулсан болно.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

*Хүснэгт 4 Төлбөрийн акт,* албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| **Акт** | **4** | **14,760.6** | **4** | **14,760.6** | **100,0** |
| **Албан шаардлага** | 2 | 135,165.4 | 2 | 135,165,4 | 100,0 |
| **Зөвлөмж** | | | | | |
| **Нийт дүн** | **6** | **149,926.0** | **6** | **149,926.0** | **100,0** |

Урьд оны аудитын төлбөрийг барагдуулж, зөрчлийг арилгасан гэж үзсэн.

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймаг Баянчандмань суман дахь политехникийн коллеж нь дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудал бол бүх төрлийн хөрөнгийн бүртгэлийн тооллого, тооцоо бодолтыг авч үзэх

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 77,800.0 мянган төгрөгийн алдаа илэрснээс аудитын явцад 77,800.0 мянган төгрөгийн алдааг залрууллаа.Үүнд:

НҮБ-аас хандив тусламжаар ирсэн эд зүйл, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн кабинетын тохижилтод зарцуулсан 77,800.0 мянган төгрөгийг хөрөнгийн холбогдох дансанд бүртгээгүй зөрчил илэрлээ. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д “жинхэнэ хэрэгжилтийн” зарчмыг баримтална, 14 дүгээр зүйлийн 14.4-т “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлийг заавал бүртгэнэ”, 14.4.2-т “Хөрөнгө, хөрөнге оруулалт, авлага” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “Тохиолдсон байх“, “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсний дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн болно.

Аудитаар нийт 18,920.0 мянган төгрөгийн 3 зөрчил илэрснээс 460.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож 18,460.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 албан шаардлага хүргүүлсэн.

### 5.1. Төлбөрийн акт:

Биологийн хөрөнгө дансанд байсан 460.0 мянган төгрөгийн мал амьтныг тооллогын бүртгэлд тусгаагүй, авлага дансанд бүртгэсэн. Авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй зөрчил илэрсэн. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д “Эд хөрөнгийн болон болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж үлдэгдлийг

баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” заалт санхүүгийн тайлангийн “эрх ба үүрэг” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.2-т “Хөрөнгийн тооллогыг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хийгээгүй, баримтжуулаагүй, баталгаажуулаагүй” гэж заасныг үндэслэн төлбөрийн акт тогтоов.

**5.2. Албан шаардлага:**

1.Мөнгөн гүйлгээний орлого, зарлагыг шалгахад 2023 оны 12 дугаар сарын 17-нд Санжидбуян ХХК-д дэлгэц авахаар гэрээ хийж, 16,750.0 мянган төгрөгийг шилжүүлсэн болович гэрээнд заагдсан хугацаанд 16,750.0 мянган төгрөгийн бараагаа аваагүй байна. Энэ нь Төсвийн хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”, Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7-д “Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсөв зарцуулаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна. Санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх”, “Оршин байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан” Албан шаардлага өгөх,төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.4-д “Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан, зах зээлийн үнээс өндөр, эсвэл шаардлагагүй хөрөнгө олж бэлтгэсэн” гэж заасныг үндэслэн албан шаардлага өгөв.

2.Үндсэн хөрөнгө дансанд хийгдсэн гэнэтийн тооллогоор 1,710.0 мянган төгрөгийн үнэтэй ДТ75 трактор данс бүртгэлтэй болович биетээр байхгүй. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-д “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлийг заавал бүртгэнэ”, 20 дугаар зүйлийн 20.2.6-д “Эд хөрөнгийн болон болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” заалт санхүүгийн тайлангийн “Эрх ба үүрэг” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.2-т “Хөрөнгийн тооллогыг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хийгээгүй, баримтжуулаагүй, баталгаажуулаагүй” гэж заасныг үндэслэн албан шаардлага өгөв.

Дээрх төлбөрийн акт, албан шаардлагын биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2023 оны 5 дугаар сарын 25 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| НҮБ-ийн хандиваар ирсэн хөрөнгийг | 1 | 77,800.0 | | | | | 1 | 77,800.0 | | | | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| холбогдох хөрөнгийн дансанд бүртгэж аваагүй | | | | | | | | | | | | |
| | 1 | 77,800.0 | | | | | 1 | 77,800.0 | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Биологийн хөрөнгө дансанд байсан малыг авлага дансанд бүртгэсэн боловч баталгаажуулаагүй | 1 | 460.0 | 1 | 460.0 | | | | | | | | |
| Гэнэтийн тооллогоор ДТ 75 трактор данс бүртгэлд байвч биетээр байгаагүй | 1 | 1,710.0 | | | 1 | 1,710.0 | | | | | | |
| Төлбөр нь төлөгдсөн боловч бараагаа аваагүй авлага | 1 | 16,750.0 | | | 1 | 16,750.0 | | | | | | |
| Дүн | 1 | 18,920.0 | 1 | 460.0 | 2 | 18,460.0 | | | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| Шилэн дансанд байршуулах 159 мэдээллээс 153 мэдээллийг хугацаанд байршуулж6 мэдээлэл хугацаа хоцроож байршуулсан | 1 | 32,000.0 | | | | | 1 | 32,000.0 |
| Дүн | 1 | 32,000.0 | | | | | 1 | 32,000.0 |
| Нийт дүн | | | | | | | | |

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр
Утас:  +976  70272582,  +976  70273204
И –мэйл: tuv@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn